

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН “ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ-ГАЗАР ТАРИАЛАН” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал - Газар тариалан” үндэсний чуулганаас гаргасан саналуудыг үндэслэн Улсын Их Хурал, Засгийн газар болон мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, эрдэмтэн, судлаачдад хандан зөвлөмж гаргаж байна.

Нэг. Улсын Их Хуралд:

- “Тариалангийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, газар тариалангийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;
- Тариалангийн салбарт даатгалын оновчтой тогтолцоог сонгож нэвтрүүлэх, тариалангийн даатгалын хуультай болох;
- Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах;
- Ургамлын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалт, үрийн аж ахуйн тогтолцоог боловсронгуй болгох;
- Хөдөө аж ахуйг хоршооллын хэлбэрээр хөгжүүлэх, гадаад орны сайн туршлага, шинжлэх ухааны ололт, үр дүнг судлах, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай бодлогын дэмжлэг үзүүлэх;
- Газар олголт, газрын харилцаатай холбоотой эрх зүйн шинэчлэл хийх;

Хоёр. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, урт дунд хугацааны бодлогын баримт бичиг болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд:

- Салбарын боловсон хүчний дутагдалтай байдалд онцгой анхаарч, хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, мэргэжилтэй боловсон хүчин, мэргэшсэн тариаланчдыг үе шаттайгаар бэлтгэх;
- “Монгол Улсад газар тариалан эрхлэх систем” технологийн баримт бичгийг мөрдлөг болгож, хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, зохистой ээлжлэн тариалалт бүхий дэвшилтэт технологи нэвтрүүлэх, түүнд нийцсэн техникийн шинэчлэлийг эрчимжүүлэх;
- Жил бүрийн ургацаас 100-гаас доошгүй мянган тонн стандартын шаардлага хангасан хүнсний улаан буудайг стратегийн нөөцөд худалдан авч нөөц бүрдүүлэх, тариаланчдын борлуулалтыг дэмжих;
- Тариаланчид, ногоочид, жимсчдийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг тогтвортойгоор үргэлжлүүлэх;
- Өвөл, зуны хүлэмжийн цогцолбор, жимс жимсгэний төрөлжсөн аж ахуй байгуулахад Засгийн газрын баталгаа гаргаж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулж, хөрсний үржил шимийг хамгаалах;
- Үр тариа, тэжээлийн болон сэлгээний таримлын нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх, үр сортын тогтолцоог зах зээлийн харилцаанд шилжүүлж 4 жил тутамд шинэ сортын үрээр шинэчлэх, Улсын үрийн

- нөөцийг мэргэжлийн яамны харьяалалд шилжүүлэх асуудлыг судалж, Засгийн газарт оруулах;
- Хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улаан буудай, хүнсний ногооны үр үржүүлгийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж урамшуулал олгох тогтолцоог бий болгох;
 - Төмс, хүнсний ногоог дахин боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой жижиг, дунд үйлдвэрүүдийг хөдөө орон нутагт байгуулахад урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх;
 - Үр тарианы үтрэм, элеватор, төмс, хүнсний ногооны зоорь, агуулахын багтаамжийг нэмэгдүүлэх, аймгийн төвүүд, томоохон суурин газарт механикжсан агуулахууд байгуулахыг бодлогоор дэмжих;
 - Төрийн худалдан авалт хийдэг төсвийн байгууллагууд зөвхөн дотооддоо тарьж ургуулсан төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, боловсруулсан бүтээгдэхүүнийг худалдан авдаг тогтолцоог бий болгох;
 - Нийслэл хот, томоохон суурин газруудад төмс, хүнсний ногооны хадгалалт борлуулалт, тээвэр ложистикийн төвүүдийг байгуулах;
 - Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, ургамал хамгааллын бодисын чанар, найрлагыг тодорхойлох, таримал ургамал, хөрс, усан дахь пестицидийн үлдэгдлийг тогтмол хянах лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
 - “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд агро-ойн аж ахуй байгуулах, жимс жимсгэний суулгац үржүүлгийн төв болон жимс, жимсгэнийн цэцэрлэгийн аж ахуйг хөгжүүлэх;
 - Дилер аж ахуйн нэгжүүдэд төрөөс урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргах, хүүгийн төлбөрийн зөрүүг төлөх зэргээр техникийн шинэчлэлд санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлж, гадаад, дотоод хөрөнгө оруулалтыг дэмжин хамтран ажиллах;
 - Цаг агаарын нөлөөллөөс ангид, байгаль экологид ээлтэй, усанд хэмнэлттэй технологи нэвтрүүлэх, услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах, шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
 - Хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлж, бүс нутагтаа органик хүнс экспортлогч орон болох зорилтын хүрээнд чуулганаас гаргасан Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах байнгын ажлын хэсэг байгуулж ажиллах.

ЧУУЛГАНД ОРОЛЦОГСОД

2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр
Улаанбаатар хот
Төрийн ордон